



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**


48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn

2018.02.14 № 76
танай _____-ны № _____-т

**САЙНЦАГААН СУМЫН ГОВИЙН ИРЭЭДҮЙ
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ЭРДЭНЭБОЛД ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд албан шаардлага хүргүүлж байна. Хавсралт..... хуудас

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ТӨВСАНАА

D:\office\Alban bichig\A5\Хүргүүлэх тоот.docx



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/27 ДУА-2018/89/СТА-ТЦЗ Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад багш нарт 5 жил тутамд нэг удаа олгодог тэтгэмжийг 60 сар хүрээгүй байхад олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Боловсролын тухай хуулийн 43.1.7-д /Дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох / заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн төсвийн шууд захирагч Д.Эрдэнэболд, нягтлан бодогч Н.Эрхэмбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ  Д.ЭРДЭНЭБОЛД
НЯГТЛАН БОДОГЧ  Н.ЭРХЭМБАЯР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.